



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №04

2019 оны 1-р сарын 28-наас, 2-р сарын 01

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 02 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **23** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 17(74%) галзуугийн эрсдэлд өртсөн, 4(17.4%) хачигт халдвар, 1(4.3%) хумхаа, 1(4.3%) ям өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдээд байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Өвөрхангай, Орхон, Говь-Алтай, **Дундговь** аймгаас галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 17 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23%-иар, эпидемиологийн 3-р долоо хоногтой харьцуулахад 6 сэжигтэй тохиолдлоор тус тус илүү байна.



Энэ долоо хоногт Дундговь аймгийн Сайнцагаан сумаас галзуу өвчний эрсдэлд өртсөн 1 тохиолдол мэдээлэгдсэн. Иргэн “Б” нь 50 настай, эмэгтэй. 01 дүгээр сарын 28-ны өдөр эзэнтэй нохойд уруулсан. Өвчтөний биеийн байдал дунд, орчиндоо харьцаатай, баруун хацар, зүүн тахим, хонгондоо (1-2 соёо) урагдсан шархтай. 01 дүгээр сарын 28-нд Сайнцагаан сумын ЭМТ-д хандаж галзуугийн эсрэг вакцины I-р тунг хийлгэсэн. ЗӨСҮТ-өөс 01 дүгээр сарын 29-нд ийлдэс эмчилгээг эхэлсэн. Нохойг уяж хяналтад авсан.

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

2019 оны 02 дүгээр сарын 01-ны байдлаар Баянхонгор аймгийн Баянцагаан сум, ХӨСҮТ-өөс хачигт риккетсиозын сэжигтэй тохиолдол тус тус 1 бүртгэгдээд байна.

Монгол улсад:

Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

Хэнтий аймгийн (Өмнөдэлгэр, Хэрлэн), Өвөрхангай аймгийн (Баруунбаян-Улаан), Хэнтий аймгийн (Дархан), Булган аймгийн (Сайхан) сумдад галзуу өвчний мал, амьтны өвчлөл бүртгэгдэж, аймгийн МЭАЦТ-ийн шинжилгээгээр батлагдсан. Тус сумдын Засаг даргын захирамжаар 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон байна.

Эх сурвалж: ОБЕГ

Шүлхий өвчин:

Дорнод аймгийн Матад сумын 4-р багийн “Аман-Ус” гэдэг газар малчин “М”-ын 2 бяруу 01 дүгээр сарын 27-ны өдөр мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул дээж авч УМЭАЦТЛ-д шинжлүүлэхэд 01 дүгээр сарын 29-ны өдрийн хариугаар шүлхий өвчин болон нь батлагдсан. Тус сумын Засаг даргын захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоогоод байна. Голомтод нийт 3 өрхийн 59 үхрийг тусгаарлаж, 35 өрхийн 2399 үхрийг вакцинжуулсан.

Эх сурвалж: ОБЕГ

Хорт салст халуурал:

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Баянбулаг багийн “Талын цагаан худаг” гэдэг газар малчин “М”-ын 5 үхэр 01 дүгээр сарын 03-ны өдөр мал, амьтны халдварт өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул дээж авч УМЭАЦТЛ-д шинжлүүлэхэд 01 дүгээр сарын 25-ны өдрийн хариугаар хорт салст халуурал өвчин болон нь батлагдсан байна. Тус сумын Засаг даргын захирамжаар 14 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосон. мөн голомтод нийт 2550 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийгдсэн байна.

Эх сурвалж: ОБЕГ

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Олон улсад:

Мал, амьтны галзуу өвчин:


Малайз улсын ХААЯ-наас мэдээлснээр Сарабак хотын Кучинг мужид мал, амьтны галзуу өвчнөөр 1 нохой өвчилж үхэн, 2 нохойг устгасан байна. Тус хотод 11-р сарын 21-нээс, 01-р сарын 14-ны хооронд нийт 8541 нохой, 101836 муурыг вакцинжуулсан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шүлхий өвчин:

ОХУ-ын ХААЯ-наас мэдээлснээр 01-р сарын 24-нд Приморскийн край хотын нэгэн бүс нутгийн гахайн аж ахуйд “0” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин бүртгэгдсэн. Голомтод нийт 51337 гахай өртөмхий байснаас, 1302 нь өвчилж, 89 гахайг устгаж халдваргүйтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Мал, амьтны галзуу өвчин:


Малайз улсын ХААЯ-наас мэдээлснээр Сарабак хотын Кучинг мужид мал, амьтны галзуу өвчнөөр 1 нохой өвчилж үхэн, 2 нохойг устгасан байна. Тус хотод 11-р сарын 21-нээс, 01-р сарын 14-ны хооронд нийт 8541 нохой, 101836 муурыг вакцинжуулсан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шүлхий өвчин:


ОХУ-ын ХААЯ-наас мэдээлснээр 01-р сарын 24-нд Приморскийн край хотын нэгэн бүс нутгийн гахайн аж ахуйд “0” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин бүртгэгдсэн. Голомтод нийт 51337 гахай өртөмхий байснаас, 1302 нь өвчилж, 89 гахайг устгаж халдваргүйтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Гахайн сонгомол мялзан өвчин:

2019 оны 01 дүгээр сарын 30-нд Япон улсын Хөдөө аж ахуйн яамнаас мэдээлснээр тус улсын Какамигахара хотын Гифу мужийн гахайн аж ахуйд 01 дүгээр сарын 28-нд гахайн сонгомол мялзан өвчин гарч, 1662 гахай өртөмхий байснаас, 1 гахай өвчилж үхэн, 1661 гахайг устгаж ариутгал, халдваргүйжүүлэлт хийгдсэн.



Эх сурвалж: ДАЭМБ

Шүлхий өвчин:


2019 оны 01 дүгээр сарын 30-нд Өмнөд Солонгос улсын Хөдөө аж ахуйн яамнаас мэдээлснээр Аньсон хотын Гвеонгги-до мужид 01 дүгээр сарын 29-нд “0” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин бүртгэгдсэн. Голомтод нийт 97 үхрийг устгаж, халдваргүйжүүлэлт хийгдсэн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Хэл хөхрөх өвчин:

2019 оны 01 дүгээр сарын 29-нд Грек улсын Хөдөө аж ахуйн яамнаас мэдээлснээр тус улсын Вогеио Айгаио мужийн үхрийн аж ахуйд 01 дүгээр сарын 28-нд малын хэл хөхрөх өвчин бүртгэгдэж, 91 үхэр өртөмхий байснаас, 1 үхэр өвчилсөн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

ЗӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгж